

**БАЯНХОНГОР АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН
НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 10


Номгон

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны А/49 дүгээр захирамжаар батлуулан, аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний зардлаас 5.0 сая/төг, Аймгийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 5.0 сая/төг төсөвлөн 6 зорилтын хүрээнд 26 арга хэмжээ төлөвлөн 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг 7 удаа зохион байгуулж, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах төлөвлөгөөт сургалтыг 10 удаа, төлөвлөгөөт бус сургалтыг 10 удаа захиалгат сургалтыг 11 удаа 29 сэдвээр зохион байгуулж аймгийн хэмжээнд 13,000 төрийн албан хаагчийг хамруулан ажилласан. Мөн онцлог ажлын хувьд “Авлигын эсрэг-Гэрэл түгээе” аяныг зохион байгуулсны үр дүнд фейсбүүкийн нүүр зургаа 751 албан хаагч шинэчлэн хүүхдийн ертөнцийг хүндэлье агуулга бүхий видео 5 ширхэг, авлигын эсрэг уриалга бүхий видео 4 ширхэг, тухайн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан агуулга бүхий видео 13 ширхгийг тус тус бүтээж олон нийтэд түгээн ажилласан. Энэ онд аймгийн хэмжээнд шинээр авлигын гэмт хэрэг 17 бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна. Цахим хуудасны ил тод байдал 100 хувьтай. Шударга байдлын 2023 оны үнэлгээ 75.2 хувь болж өмнөх оноос 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1.1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах ажлын хүрээнд:

Авлигатай тэмцэх газраас бэлтгэгдсэн аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилгаа зохион байгуулах эрх бүхий сургагч багш нар хамтран Авлигын гэмт




хэргээс урьдчилан
сэргийлэх, түүний хор
уршиг, Нийтийн албан
тушаалтанд тавих
хориглолт хязгаарлалт,
авлигын гэмт хэргийг

эрүүгийн хуульд хуульчилсан байдал, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь зэрэг сэдвээр 5 сумын 710 иргэд, төрийн албан хаагчдад сургалт

зохион байгуулж, 2 төрлийн 1420 ширхэг гарын авлагыг түгээж, 23 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилласан.

Төрийн байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг **“Авлигын эсрэг-Гэрэл түгээе” уриан дор** 2024 оны 05 дугаар сарын 27-31-ний өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулан ажилласан.

Аяны хүрээнд 6 сум 20 байгууллагын 751 албан хаагчид идэвхтэй оролцож фейсбүүкийн нүүр зургаа **“Авлигын эсрэг-Гэрэл түгээе”** хүрээгээр шинэчилсэн.



Мөн “Хүүхдийн ертөнцийг хүндэлье” гэсэн агуулга бүхий видео 5, авлигын эсрэг уриалга бүхий видео 4, байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан агуулга бүхий видео 13 төрлийг тус тус бэлтгэж, олон нийтэд түгээн ажилласан.

“Төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам” сэдвээр 35 байгууллагын 652 албан хаагчид сургалт зохион байгуулсан.

Нээлттэй ил тод байдлын талаар зарим сум, байгууллагын зохион байгуулсан онцлог ажлын талаар:


Нийгмийн даатгалын газар: Байгууллагынхаа гадна хэсэгт “Бид авлигыг хэрхэвч зөвшөөрөхгүй” постерийг байршуулж Нийгмийн даатгалын газар 2024 оны 05 дугаар сараас эхлэн “Төрийн үйлчилгээг



төвөггүй хүргэе” уриан дор чөлленж өрнүүлэн ажилласны үр дүнд нийгмийн даатгалын үйлчилгээг сурталчилж иргэдийн сонирхсон асуултад хариулсан 2 төрлийн видеог иргэдэд сурталчлан ажилласан байна.

Хүрээмарал сум: Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, худалдан авах ажиллагаа, төсөв хөрөнгөтэй холбоотой мэдээлэл агуулсан 2 төрлийн сонинг 400 ширхгийг хэвлүүлэн иргэдэд тарааж ажилласан байна.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар: Байгууллагын фейсбүүк пэйж хуудсаар дамжуулан Авлигатай тэмцэх газар болон АТГ-Олон нийтийн төв фейсбүүк пэйж хуудсанд байршиж буй мэдээллийг түгээж, Авлигын эсрэг уриалга, авлигын мэдээллийг тогтмол иргэд, олон нийтэд мэдээлэлж ажилласан.



Шинэжинст сум: Гомдол, мэдээлэл хүлээн авах 110 дугаартай утасны постерыг ашиглан Авлигатай тэмцэх газрын албан ёсны фэйж, өргөдөл гомдол хүлээн авах 1111 төв, irgen.bayankhongor.gov.mn сайтыг 61 төрийн албан хаагч, 22 иргэнд сурталчлан сургалт, мэдээлэл хийсэн.

Баянхонгор сум /хот/-ын Засаг даргын Тамгын газар

Posted by Davaasuren Batbayar
20h · 🌐


#авлигынэсрэгнэгдье
#ҮгүйГэжХэлээдӨөрчилъе



Баянхонгор сум /хот/-ын Засаг даргын Тамгын газар

Posted by Davaasuren Batbayar
21 Oct · 🌐


#авлигынэсрэгнэгдье
#110



Баянхонгор сум /хот/-ын Засаг даргын Тамгын газар


Posted by Davaasuren Batbayar
20h · 🌐

#авлигынэсрэгнэгдье
#ҮгүйГэжХэлээдӨөрчилъе
#110



See insights and ads

👍 3



Boost post

3 shares

Баянхонгор сум /хот/-ын Засаг даргын Тамгын газар

Posted by Davaasuren Batbayar
21 Oct · 🌐

#авлигынэсрэгнэгдье



youtube.com
АТГ - Төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим

See insights and ads

Boost post

👍 3

2 shares

👍 Like

💬 Comment

✉ Send

🔄 Share

Тус сум нь долоо хоног бүрийн Даваа гарагт 17 цагаас иргэдтэй мэдээлэл солилцох тогтсон өдөртэй болсноор 558 иргэн үйлчилгээ үзүүлж төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.



1.2.Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад тухай бүр дэмжлэг үзүүлэх хүрээнд:

Шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоор 15 сум, 51 байгууллагын 4700 гаруй иргэд, албан хаагч, оюутан сурагчдад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус захиалгат сургалтыг зохион байгуулж, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэн ажиллалаа.

Шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлын хүрээнд 15 хууль тогтоомжоор 30 гаруй төрлийн постер бэлтгэж орон нутгийн телевиз, аймгийн www.bayanhongor.gov.mn цахим хуудас, хэлтсийн PAGE хуудас болон мэдээллийн самбараар тогтмол сурталчлан, иргэд, төрийн байгууллагуудад түгээн ажилласан.

Мөн шинэчлэн найруулга хийгдэх 1 хууль, 10 журмын төсөлд санал авах хэлэлцүүлгийг зохион байгуулж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.

1.3.Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх ажлын хүрээнд:

Тухайн оны төсвийн төсөл оруулах мэдээллүүдийг хуулийн цаглаварт хугацаанд нь Шилэн дансанд байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтэд мэдээлж ажилласан.

Мөн аймгийн www.bayankhongor.gov.mn цахим хуудасны шилэн данс цэсэд тухайн жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, аудитын дүгнэлт, зөвлөмж, орон нутгийн хөгжлийн сан, болон холбогдох бусад мэдээллийг тогтмол байршуулж ажилласан.

1.4.Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах ажлын хүрээнд:



Согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл олгох чиглэлээр:

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ГХУСАЗСЗ-өөс 1.0 сая/төг-ийг шийдвэрүүлж, согтууруулах ундаа

худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 380 гаруй аж ахуйн нэгжид цахимаар болон танхимаар 4 удаагийн сургалт зохион байгуулж ажилласан.

Согтууруулах ундаагаар үйлчлэх үүрэг бүхий ажилтнуудын хариуцлагатай үйлчилгээний сургалтад 21 аж ахуйн нэгжийн 92 ажилтныг хамруулсан. Согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг сунгуулах, шинээр авах 146 аж ахуйн нэгжийн хүсэлтийг цаасан болон цахимаар хүлээн авч, ажлын хэсгийн хурлыг 43 удаа хуралдуулж, 46 дүгнэлт гарган шийдвэрлэж, тусгай зөвшөөрөл олгон ажиллалаа.

Согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийн материалыг e-business.mn цахим хаягаар хүлээн авч, шийдвэрлэн ажиллаж байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох чиглэлээр: Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт бүхий өргөдлийн маягтыг bayanhongor.gov.mn цахим хуудсанд байршуулж тусгай зөвшөөрөл олгох процессыг цахимд шилжүүлэхээр И-монголиа академитай хамтран ажиллах хүсэлтийг өгсөн. Эхний хасаг жилийн байдлаар Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдоогүй болно.

Боловсролын тусгай зөвшөөрөл олгох чиглэлээр: Боловсролын байгууллагуудаас энэ онд зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтээ Баянхонгор сумын 15,16 дугаар цэцэрлэг, төрийн бус өмчийн “Баянцэцүүхэй” цэцэрлэгүүд ирүүлж хугацааг сунгасан. Мөн Бөмбөгөр сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөл баригдаж байгаа тул 2 бүлэг шинээр, Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын шинээр баригдаж байгаа тул 2 бүлэг нэмэхээд тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт хийсэн.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/28 дугаар тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн нэршлийг аймгийн Засаг даргын захирамжаар 32 сургуулийн нэрийг өөрчлөн тогтоосон.

Эрүүл мэндийн тусгай зөвшөөрөл олгох чиглэлээр: Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс ажлын төлөвлөгөөнд 12 арга хэмжээ тусгагдсанаас 100 хувь хэрэгжсэн. Тус комисс нь 13 удаагийн хурлаар давхардсан тоогоор 75 байгууллагын асуудлыг хэлэлцэн, тушаалаар сунгалт-44, шинэ-4, хүчингүй-5, сэргээсэн-4, нэмэлт өөрчлөлт-5, түдгэлзүүлсэн-5, бусад 8 байгууллага байна.

Сунгалт болон нэмэлт өөрчлөлтийн хүсэлтийг EMongolia цахим программын les.e-business.mn системээр сунгалт болон нэмэлт өөрчлөлт-43 хүсэлт хүлээн авч бүрэн шийдвэрлэсэн. Хурлын шийдвэрийн дагуу тушаал 30, албан бичиг 25, албан мэдэгдэл 31 хүргүүлэн хамтран ажилласан. Газрын даргын удирдамжийн дагуу 25 байгууллагад ажлын байрны үнэлгээ үнэлгээ хийгэж зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна.

Ашиг сонирхлын зөрчилгүйгээ илэрхийлсэн мэдэгдлийг 7 гишүүнээс дувхардсан тоогоор гаргаж ажилласан. Тус мэдэгдлийг шилэн данс болон байгууллагын вэйб сайтад байршуулан ажилласан.

1.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах ажлын хүрээнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга) нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдсөн бөгөөд тус хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шинэчлэн батлагдсан журам, тендерийн жишиг баримт бичигүүдийг худалдан авах ажиллагаа зохион байгуулахад мөрдлөг болгон ажиллаж байна. Монгол улсын Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолын дагуу аймгийн Худалдан авах ажиллагааны газрыг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр аймгийн Засаг даргын 2024 оны А/08 дугаар захирамжаар байгуулсан.

Баянхонгор аймгийн 2024 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгон батлагдсан төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13 нэр төрлийн 34.9 тэрбум, үрсгал төсвөөр 2 нэр төрлийн 47.8 сая төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 86 нэр төрлийн 21,3 тэрбум төгрөгийн, нийт 101 нэр төрлийн 56,2 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар холбогдох сумуудад 7,8 тэрбум төгрөгийн 39 төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 13 нэр төрлийн 34,9 тэрбум, урсгал төсвөөр 2 нэр төрлийн 47,8 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай 13,5 тэрбум төгрөгийн 47 төсөл арга хэмжээ, нийт 62 нэр төрлийн 48,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгосон төлөвлөгөө 100%-ийн биелэлттэй явагдаж байна. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 2024 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг Засгийн газрын худалдан авах ажиллагааны “tender.gov.mn” болон Баянхонгор аймгийн “bayankhongor.gov.mn” сайт, шилэн дансанд байршуулан олон нийтэд сурталчилсан. Өөрийн гэсэн Вэб сайт хийлгэхээр захиалга өгч, гэрээ байгуулсан 2024 оны 12 дугаар сард багтаан ашиглаж эхлэнэ.

Дээрх нийт тендер нь зарлагдсан төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 978,5 сая төгрөг, орон нутгийн төсвийн батлагдсан хөрөнгө оруулалтаас 292,2 сая төгрөг, нийт 1,2 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлтийг гарган ажиллаа. Тайлант хугацаанд зохион байгуулагдсан төсөл, арга хэмжээний явцыг ангилбал:

Холбогдох сумдад эрх шилжүүлсэн 39 буюу 7.8 тэрбум төгрөг-38.6%

Тендер нь зарлагдсан-4 буюу 705.0 сая төгрөг-4.0%.

Гэрээ байгуулагдсан -58 буюу 48.0 тэрбум төгрөг-57.4%

Үнэлгээний шатандаа яваа- 1 буюу 3.9 тэрбум төгрөг-1.0% бөгөөд

Тендер нь зарлагдаагүй нэг ч төсөл арга хэмжээ байхгүй байна.

Мөн 2024 оны тендерийн урилгыг tender.gov.mn, bayankhongor.gov.mn сайт болон байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан.

Тухайн тендерт оролцогчийн шалгарсан болон шалгараагүй шалтгаан, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn сайтад тогтмол оруулж ажилласан.

Тухайн тендерт оролцогчийн шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсны дараа гэрээг цахим системд оруулна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журамд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг жилийн эцсийн байдлаар цаг хугацаанд нь гаргаж Bayankhongor.gov.mn сайтад байршуулж ажилласан. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, хяналт шалгалтын дүнг Bayankhongor.gov.mn, шилэн дансанд тогтмол байршуулж ажилласан.

Худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 10 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд Төрийн худалдан авах ажиллагаанд мэргэшүүлэх "А3" сертификат олгох сургалтыг "Худалдан авах ажиллагааны сургалт судалгааны төв" ТББ-тай хамтран зохион байгууллаа. Сургалтад аймгийн төвийн байгууллага болон 20 сумдаас төрийн алба, төрийн бус байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл нийт 79 хүн хамрагдснаас 39,2% буюу 31 хүн шалгалтанд тэнцэж, шинээр төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сертификат авлаа.

Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 09 цаг 30 минутаас 2 ээлжээр А3 сертификат олгох давтан шалгалтыг зохион байгуулж нийт 43 хүн хамрагдснаас 48,8 буюу 21 хүн тэнцэж сертификат авсан.

Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдэд цахим худалдан авах ажиллагаанд оролцоход шаардлагатай тоон гарын үсгийг 2024 онд шинээр 50 аж ахуйн нэгжид олгохоор төлөвлөсөн ба жилийн эцсийн байдлаар 50 ширхэгийг олгож дууссан. Мөн давхардсан тоогоор 30 гаруй аж ахуйн нэгжийн Тоон гарын үсгийг сунгасан байна.

Тендер шалгаруулалт явуулах явцад гарсан аливаа санал гомдлыг шийдвэрлэн ажиллахаас гадна холбогдох байгууллагад шилжүүлж "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу шийдвэрлэн ажиллаж байна.

Жилийн эцсийн байдлаар 61 үнэлгээний хороо байгуулагдсан давхардсан тоогоор 114 шийдвэр гаргасан бөгөөд шийдвэр бүрийг цахим хуудсанд байршуулж, үнэлгээний хорооны бүрэлдэхүүн тус бүрт иргэний төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөллийг байнга оролцуулан ажиллаж, жилийн эцэст урамшуулал олгож байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын баталсан удирдамжийн дагуу "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан төсөвт байгууллагуудын худалдан авах ажиллагааны явц,


хэрэгжилтийг хянах, цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах ажлыг хангайн 10 сумдад 2024 оны 10 дугаар сарын 21-нээс 29-ний өдрүүд, говийн 10 сумдад 2024 оны 11 дүгээр сарын 5 наас 11 дүгээр сарын 9-ний өдрүүдэд худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнүүд зохион байгуулж ажилласан.

Баянхонгор сумд үйл ажиллагаа явуулдаг сургууль, цэцэрлэг, зарим төрийн байгууллагуудын 2024 онд зарласан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны явц, хэрэгжилттэй танилцан, цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг газрын даргын баталсан хөтөлбөрийн дагуу 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр төрийн архивын тасгийн хурлын зааланд зохион байгуулж ажилласан.

Худалдан авах ажиллагааны өдөр тутамын ажил болон зарлагдаж байгаа тендерийн мэдээлэл болон сар, улирал, жилийн тайланг тухай бүр иргэд болон аж ахуйн нэгжүүдэд мэдээллийг ил тод байлгах үүднээс тухай бүр байгууллагын мэдээллийн самбарт, Bayanhongor.gov.mn, umch.bkh.gov.mn сайтуудад байршуулан ажиллаж байна.

1.6.Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бүс байгууллага, иргэдийн сайн дүрын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах ажлын хүрээнд:

Хувиараа ашигт малтмал олборлогчдын холбоотой хамтран уул уурхайн зөвлөгөөний хүрээнд бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийн хэрэгжилтийн хүрээнд эрх зүйн мэдлэг олгох танхимын сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр ХАМО нарын удирдлагуудад "Авлига ба хүний эрх" сэдвээр зохион байгуулж ажилласан.



"Хөгжлийн шийдэл" ТББ-ын BEST хөтөлбөртэй хамтран төрийн байгууллагуудын авлигад өртөх эрсдэл бүхий албан хаагчдад "Авлига ба хүний эрх", "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалт" сэдвээр иргэдийн мэдэх эрхийг хангаж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх нийтийн эрх ашгийн төлөө шударга ёсыг эрхэмлэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод, шийдвэр



гаргахад нөлөөллийг бий болгож аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрх бүхий 40 албан хаагчид сургалт зохион

байгуулж, авлигын талаар эрх зүйн мэдлэг олгож хамтран ажиллаласан.

1.7. Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд:

Иргэдэд нээлттэй ил тод, шударга байдлыг бий болгох зорилт дэвшүүлэн сул орон тооны зарыг

- Аймгийн www.bayanhongor.gov.mn цахим хуудас
- Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудас
- www.facebook.com/ Баянхонгор аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл/ групп,
- Орон нутгийн телевиз,
- www.facebook.com /Нээлттэй засаг-Нэг Баянхонгор/ зэрэг цахим хуудсуудад мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлөөс төрийн жинхэнэ алба хаах сонирхолтой иргэнийг сонгон шалгаруулж, нөөц бүрдүүлэх зорилгоор нийтдээ 2 удаагийн зар тавьж 39 сул орон тоог нөхсөн

Монгол Улсын Засгийн газрын 1111 төвд тус аймгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой 46 гомдол, санал, 3 талархалыг холбогдох байгууллагад дамжуулах хуулийн хугацаанд шийдвэрлүүлж хариуг албан бичгээр хүрүүлэн ажилласан.

Аймгийн Засаг дарга сум, байгууллагын удирдах албан тушаалтнуудтай хамтран ажиллах батламж олгон, авлигагүй ажиллах талаар 134 албан



тушаалтантан баталгаа гаргасан.

1.8.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах ажлын хүрээнд:


Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн 70440001 дугаарын утсаар, www.bayanhongor.gov.mn вэб сайтаар, info@bayankhongor.gov.mn цахим шуудангийн хаягаар, Засаг даргын Тамгын газрын байр болон төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн байранд байрлах санал авах хайрцгаар мөн аймгийг Засаг дарга долоо хоног бүрийн Пүрэв гарагт иргэдийн хүлээн авч уулзаж, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Өргөдөл, гомдол, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн бичгээр болон цахимаар тус тус иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч байна. Аймгийн Засаг даргын Тамгын газарт хандан 143 өргөдөл ирүүлсний 138 өргөдөлийг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан бөгөөд хугацаа болоогүй 5 өргөдөл байна.

1.9.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах ажлын хүрээнд:


Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар: Байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн.



Аймгийн хэмжээнд 2024.01.01-ээс хойш тухайн албан тушаалд шинээр томилогдсон 18 сумын 96, 14 агентлагийн 20 нийт 116 албан хаагчдад албан үүргээ гүйцэтгэхдээ иргэдийн хүсэлтэд анхааралтай хандаж, ил тод, хариуцлагатай, ёс зүйтэй, хүнд сурталгүй ажиллах талаар чиглэл өгч "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нь", "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" сэдвээр авлигын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтыг 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр зохион зохион байгуулсан.




Авлигатай тэмцэх газарт албан хүсэлт хүргүүлсний дагуу аймгийн 165 удирдах албан тушаалтанд 2024 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн 10 цагт "Хандив авахтай холбогдсон хориглолт хязгаарлалт", "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам" зэрэг сэдвүүдээр цахим сургалт мэдээлэл зохион байгуулж хамтран ажилласан. Сургалтын үр дүнд нийтийн албан тушаалтан хуулиар хориглосон хориглолт хязгаарлалтыг зөрчихгүй байх ажиллах талаар эрх зүйн мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн.




Аймгийн хэмжээний шударга байдлын төвшин, цахим хуудасны ил тод байдал, ашиглалтыг сайжруулах, авлигын талаарх ойлголтыг нэмэгдүүлж иргэдийг соён гэгээрүүлэх, авлигын гэмт хэргийн гаралтыг бууруулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээний хүрээнд нийгэм дэх авлигын талаарх бодит нөхцөл байдлыг ухуулан суратлчилсан ёс зүйтэй сэтгүүлчдийг шалгаруулах зорилгоор аймгийн сэтгүүлч нарын дунд "Авлигыг тэвчиж үл болно" уралдааныг жилийн хугацаатай зарласан.

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааг

сайжруулах, санал солилцох уулзалтыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, холбогдох байгууллагуудад санал хүргүүлж ажилласан.



Нийгмийн даатгалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан иргэд, даатгуулагчид portal.ndaatgal.mn хаягаар нэвтрэн орж жирэмсэн амаржсаны, Хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж зэрэг 3 тэтгэмжийн хүсэлтийг цахимаар илгээх. Мөн Сайн дурын даатгалын гэрээг цахимаар байгуулдах нөхцөл бүрдсэн. Ингэснээр заавал өөрийн биеэр ирж сайн дурын даатгалын гэрээ байгуулах шаардлагагүй болсон. Авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан контент бэлтгэн Баянхонгор аймаг дахь эрүүл мэндийн даатгалын хэлтсийн цахим хуудсанд байршуулж 84 иргэний хандалт авсан.



Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газар 05 дугаар сарын 17-ны өдөр “Хууль сурталчлах” нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 100 иргэнд эрх зүйн мэдээлэл өгсөн байна.

Баянхонгор сум авлигын хор хөнөөлийг ухуулан таниулсан гаргын авлагыг 100 иргэнд, Авлигын талаарх үнэн бодит мэдээллийг хүлээн авах 110 дугаарыг сурталчилсан зурагт хуудасыг 95 хүнд танилцуулж тараасан.



"Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам" сэдвээр Баянхонгор сум 50 албан хаагчид сургалт зохион байгуулсан.

Улсын бүртгэлийн хэлтэс "Төрийн үйлчилгээ иргэдэд ойрхон" уриатай нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг Баянговь, Жаргалант сумдад зохион байгуулж 140 гаруй бүртгэл хийж, давхардсан тоогоор 100 гаруй иргэнд эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Мөн алба хаагчид иргэдэд бүртгэлийн үйлчилгээг үзүүлэхдээ авлигаас ангид байх амлалтын дэвтэрт гарын үсэг зурж үйлчилгээ үзүүлдэг.

Төрийн аудитын газар: Төрийн аудитын газраас "Цахимд хэвшье" нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг зохион байгуулан "Авлигын эсрэг хамтдаа нэгдье" уриа бүхий авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан 100 ширхэг гарын авлагыг иргэд төрийн албан хаагчдад түгээсэн байна.



Нийт албан хаагчдад Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс 2024.06.10-ны өдөр гаргасан төрийн албан хаагчдыг улс төрийн нам, эвсэлээс ангид байх Мэдэгдлийг танилцуулж олон нийтийн сүлжээгээр түгээж ажиллаж байна.

Нэмэгдсэн зарчим = "ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх"

Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл /39/



- албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг бэлгийн болон хувийн ашиг сонирхолдоо нийцүүлэн аливаа хэлбэрээр дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах; /39.1.4/
- албан тушаалын бүрэн эрхээ шашны, эсхүл шашингүй үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглах; /39.1.8/

- сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгө, албаны унаа ашиглах; /39.1.6/
- албаны бус зорилгод байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших; /39.1.11/




Баянхонгор сумын ЗДТГ: Байгууллагын хэмжээнд авлигын 110 дугаарыг сурталчлан таниулж, Баянхонгор /хот/ сумын Засаг даргын Тамгын газар фейсбүүк



пэйж хуудас болон 10 багийн иргэдийн фейсбүүк пэйж хуудсаар дамжуулан иргэдэд 110 дугаарыг цахимаар сурталчилсан. Доорх 2 постерийг хэвлэн гаргаж Баянхонгор сумын 10 багт тараан өгч, багийн хөгжлийн төвөөр үйлчлүүлж буй иргэдэд тарааж



өгсөн. Одоогийн байдлаар нийт давхардсан тоогоор 312 хүнд тараасан. Мөн “Авлигын эсрэг нэгдье”, “Гомдол, мэдээлэл хүлээн авах утас 110”, “Авлига би авахгүй, өгөхгүй” гэсэн жижиг стикерийг хэвлүүлэн Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын төв байр болон 10 багийн иргэд тогтмол харж болох хаалган дээр




нааж иргэдэд таниулах сурталчилгаа хийсэн.

Заг сум: цахимаар үйлчилгээ авах И монголиа тоон гарын үсэг олголт ашиглалтын сурталчилгааг 230 хүнд хүргэж цахимаас үйлчилгээ авах арга зүйг зааж өгснөөр 30 хүн лавлагаа авч цахим үйлчилгээг ашигласан. Тус үйлчилгээний талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авахад үйлчилгээг дэмжсэн байна.

Бөмбөгөр сум: Эцэг эх арсан, хамгаалагч харгалзан дэмжигчдийн өдөрлөг зохион байгуулж, 182 хүн хамрагдсан. Эцэг эхчүүдийн дунд ГХУСАЗСЗ хамтран Дэвжээ тэмцээн зохион байгуулж 189 хүн хамруулсан байна

Баянговь: Авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчилан танилусан, уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилсан гарын авлага мэдээллийг 250 иргэнд тарааж ажилласан

байна.



Галуут сум: Та авлигагүй бүсэд нэвтэрлээ бивчэрийг наалт хэлбэрээр байгууллагуудын 1,2 дугаар давхруудад байрлуулсан байна.



Санхүүгийн хяналт дотоод аудитын алба: Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний төсөвт 180 байгууллагын шилэн дансны мэдээлэлд хяналт шалгалтыг хийж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл цэстэд нийт 18 байгууллага мэдэгдлийг бүрэн байршуулаагүй байсан зөрчил илэрсэн. Тус зөрчил дутагдлыг холбогдох албан тушаалтанд чиглэл өгч арилгуулсан.

1.10.Хүүхдийн шударга байдлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

Аймгийн цахим хуудасны ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор "Авлигын эсрэг гэрэл түгээ" арга хэмжээг зохион байгуулсан. Аяныг зохион байгуулсны үр дүнд фейсбүүкийн нүүр зургаа 751 албан хаагч шинэчлэн хүүхдийн ертөнцийг хүндэлье агуулга бүхий видео 5 ширхэг, авлигын эсрэг уриалга бүхий видео 4 ширхэг, тухайн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан агуулга бүхий видео 13 ширхгийг тус тус бүтээж олон нийтэд түгээн ажилласан.



Шинэжинст ЗДТГ

4d · Q

"Авлигын эсрэг-Гэрэл түгээ"

#Нэгдье

#ҮгүйгЭжХэлээдӨөрчилье... See more



53

7 comments 5 shares 1.8K plays

Шинэжинст сум: Шударга ёсны талаар хүүхдүүдтэй ярилцаж үзэл бодлыг нь сонссон 2 видео бичлэгийг сумынхаа албан ёсны пэйж хуудсуудад байрушуулсан. Сургуулийн хүүхдийн бичлэг 2,7к хүн үзсэн, 4 удаа шейр хийсэн, 50 лайктай цэцэрлэгийн хүүхдийн бичлэг 2,4к үзэлттэй 7 шейр, 59 лайк, 13 сэтгэгдэлтэй байна.

Жаргалант сум авлига, ашиг сонирхолын зөрчлийн үр нөлөө, авлигын тухай олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор 09-12 дугаар ангийн сурагчдын дунд "Авлигагүй ирээдүй" эсээ бичлэгийн уралдааныг зохион байгуулж шалгаруулан, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр урамшуулсан байна.



Авлига гэж юу бэ, түүний хор хөнөөл сэдэвт сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 32 эцэг эхэд зохион байгуулж эрх зүйн мэдлэг олгосон.

Байгаль орчин аялал жуулчлалын газар: Байгууллагын чиг үүрэг, хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор иргэдэд экологийн боловсрол олгох мэдээ, мэдээллийг өөрийн байгууллагын пэйж хуудсанд байршуулж байдлаар 83 нийтлэл оруулж давхардсан тоогоор 132270 гаруй хүнд хүрч, 200 гаруй дагагч шинээр нэмэгдсэн байна.

Иргэдийн мэдэх эрхийн хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын баруун жигүүрт байрлалтай "Нэг цонх"-ны үйлчилгээний төвийн зааланд "Шударга ёс хөгжил дэвшилд" нэртэй авлигын талаарх мэдээллийг түгээх, хүлээн авах самбар ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажилласан байна.



Тус 110 мэдээллийн самбарыг аймгийн хэмжээнд нийт 17 байгууллага тусгайлан захиалгаар хийлгэж авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээллийг

байршуулан Шударга ёс хөгжил дэвшилд уриатайгаар иргэдэд сурталчлан ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд тус хайрцагт авлигатай холбоотой санал, гомдол ирүүлээгүй байна. Тус мэдээллийн самбарын мэдээллийг улиралд 1 удаа шинэчлэн байдлаар 6 төрлийн 12 мэдээллийг байршуулан ажилласан.

Төрийн үйлчилгээг цахимжуулах, хүн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх, төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгийг байгуулан Баянхонгор аймгийн төв болон 6 сум төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийг нээж төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх боломж бүрдсэн. Мөн орон нутгийн онцлогтой 21 төрлийн тусгай зөвшөөрлийн үйлчилгээг цахимд шилжүүлээд байна.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар: Нийт ажилтан, албан хаагчдаас авлигад өртөх магадлалтай албан хаагчдын судалгааг авсан. Үүнээс нийт 8 албан хаагч өртөх магадлалтай гэж судалгааг бөглөсөн байна. Уг судалгааны дагуу албан хаагчдад 2 удаа Авлигын эсрэг хуулийн тухай сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 76 албан хаагчийг хамруулсан.

Аймгийн авлигын тандалт судалгааны нэгдсэн дүн:



Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс авлигын талаарх тандалт судалгааг 2024 оны 03 дугаар сараас эхлэн 15 дугаар сарын 31-ний өдрийн хооронд цаасан хэлбэрээр авахад 343 иргэн судалгаанд хамрагдсан байна.

Судалгаанд оролцогчдын 43.7 хувь нь 20-45 насны иргэд оролцсон бөгөөд ажил эрхлэлтийн байдлаар ангилбал төрийн албан хаагч 56,9 хувийг, хувийн хэвшлийнхэн 16,9 хувь хамрагдсан байна.

Судалгааны дүгнээс үзэхэд нийгэмд авлига хэр зэрэг байгааг мэдэхгүй байна гэж 40,4 хувь нь хариулсан байна. Харин аль түвшний албан тушаалтан авлигад хамгийн их өртөх магадлалтай вэ гэсэн асуултад удирдах албан тушаалтнууд гэж 65,5 хувь, гүйцэтгэх албан тушаалтан гэж 5,2 хувь нь, бүгд гэж 13,1 хувь нь хариулсан байна.

Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт хязгаарлалтуудыг зөрчиж албан үүргээ гүйцэтгэсний төлөө бусдаас бэлэг, шан харамж авах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөх, албаны мэдээлэл ашиглахтай холбогдсон хориглолт хязгаарлалтыг зөрчих, давхар ажил эрхлэхтэй холбогдсон хориглолт хязгаарлалтыг зөрчих тохиолдлууд ихэвчлэн гарч байгаа бөгөөд эдгээр нь Шүүх,

Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газрын, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар зэрэг төрийн захиргааны байгууллагуудад ихэвчлэн илэрдэг гэж судалгаанд оролцогчдын 51 хувь нь хариулсан байна.


Харин төрийн байгууллагаас үйлчилгээ авахад хамгийн их хүндрэлтэй, хүнд сурталтай үйлчилгээ үзүүлдэг байгууллага байна уу? гэсэн асуултад Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Шүүх, Цагдаа гэж 66 хувь нь хариулсан байна.

Дээрх судалгаанд үндэслэн 2025 оны төлөвлөгөөнд сургалт нөлөөлийн арга хэмжээг эрчимжүүлэх талаар тусган холбогдох байгууллагатай хамтран ажиллахаар шийдвэрлэсэн.


Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, авлигатай тэмцэх үйл ажиллагааг танилцуулах, орон нутаг дахь авлигын нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөх, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн хөтөлбөрийн дагуу 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр нийтийн албан тушаалтнуудад нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа.

Сургалтад оролцогч нарын хувьд төлөвлөсөн хугацаанд 98 хувийн ирцтэй оролцсон.

Сургалтад төрийн удирдах болон гүйцэтгэх 448 албан тушаалтан оролцож Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, гарч буй зөрчил дутагдал, Авлигатай тэмцэх газар, авлигаас урьдчилан сэргийлэх ажиллагаа, Авлигын гэмт хэрэг зэрэг сэдвээр мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн.



Тус сургалтаар дамжуулан хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, авлигыг үл тэвчих үзэл, хандлагыг олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор төлөвшүүлэх, хүнд суртал, чирэгдлийг арилгах, төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах, авлигын эрсдэлийг бууруулж, иргэдийг авлигын эсрэг шүгэл үлээхэд түлхэц үзүүлэх зорилгоор “Шударга бүхний төлөө шүгэл үлээж нэгдье, Авлигыг тэвчиж үл болно” уриалгад нэгдүүлэн ажилласан.



Мөн сургалтад хамрагдсан албан тушаалтнуудын дунд “Авлигын шалтгаан нөхцөлийг таслан зогсоох арга зам” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж үр дүнгийн мэдээлэлд тулгуурлан нийт төрийн албан хаагчдад чиглэсэн зөвлөмжийг гарган олон нийтийн сүлжээнд байршуулан сурталчилж ажиллалаа.

Санал:

Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлан зохион байгуулах эрх бүхий албан тушаалтныг дадлагажуулах мэргэшүүлэх танхимын сургалтад жилд 2 удаа хамруулах.

Авлигын эсрэг соён гэгээрүүлэх сургалт, нөлөөлийн арга хэмжээг зохион байгуулж үр дүнд хүрсэн олон улсын туршлага судлуулах.

ХЯНАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.САРАНГАРАВ

НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Ж.ЛХАМДУЛАМ

